

Маргааны товч

Монгол Улсын Засгийн газар 2016 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 81 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 5 дахь заалтаар “Экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээ, үнэлгээний үндэслэл болгох Монголбанкны болон зах зээлийн үнийн эх сурвалжийг тогтоохдоо Хайлуурын жоншны хувьд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хайлуур жоншны бүтээгдэхүүний FOB (www.indmin.com) Цахим хуудаст үндэслэн Монгол Улсын аж ахуйн нэгжүүдэд АМНАТ ногдуулах”-аар зохицуулжээ.

Нэхэмжлэгч нараас “хөрш орнуудтай хиллэдэг хилийн боомтын нөхцөлтэй гэрээний үнэн дээр далайн боомт хүртэлх бүх зардлыг нэмж тооцон, олоогүй орлогод АМНАТ ногдуулж байгаа нь илт үндэслэлгүй, аж ахуйн нэгжид татварын дааж давшгүй дарамт учирч, их хэмжээний татварын оронд орж цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй нөхцөл байдал үүссэн, Татварын ерөнхий хуулийн 7.3-д зааснаар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөртэй холбогдох харилцааг Ашигт малтмалын тухай хууль болон Татварын ерөнхий хуулиар зохицуулах ёстой, олон улсын зах зээл дэх борлуулалтын үнэлгээний эх сурвалжийг тогтоохдоо ямар учраас “хайлуур жонш-Хятадын хайлуур жоншны бүтээгдэхүүний FOB үнэ (www.indmin.com) байхаар заасан болох нь ойлгомжгүй, жоншны бүтээгдэхүүний хувьд олон улсын зах зээлд үнэ зарлагддаггүй тул биржид буюу олон нийтэд нээлттэй зарлагдсан үнэ гэсэн ойлголт байдаггүй” гэх үндэслэлүүдээр маргажээ.